

Оюу Толгой – Гашуун Сухайтын Автозамын Нөлөөллийг Бууруулах  
Стратегийн Талаарх Хөндлөнгийн Мэргэжлийн Шинжээчдийн  
Тайлан

**ЭЦСИЙН ХУВИЛБАР**

*Бэлтгэсэн:*

Жаред Харднер

Доктор Жеймс Мурдок

Доктор Мартен Карлссон

2017 оны 6-р сарын 21

## Товч дүгнэлт

Оюу толгой (ОТ) нь Монгол Улсын Өмнөговь аймгийн нутагт орших зэс, алтны томоохон уурхай юм. ОТ-н дэд бүтцийн нэг бүрэлдэхүүн хэсэг нь Монгол-Хятадын хил хүртэлх Оюу толгой-Гашуун сухайтын сайжруулсан автозам (ОТ-ГС) юм. Энэ автозам нь хулан (*Equus hemionus*), хар сүүлт зээр (*Gazella subgutturosa*) зэрэг зэрлэг амьтдад сөрөг нөлөө үзүүлж болзошгүй байна. Уг нөлөөлөлд хяналт шинжилгээ хийх төлөвлөгөө, нөлөөллийг бууруулах стратегийг үнэлэх зорилгоор ОТ нь хөндлөнгийн мэргэжлийн шинжээчдийн баг (Баг) байгуулсан. Энэхүү тайлан нь тус Багийн үнэлгээний үр дүн юм.

Оюу толгой-Гашуун сухайтын автозам нь Өмнөговь аймгийн нутаг дахь хулан, зээр зэрэг амьтдын амьдрах чадварт ноцтой эрсдэл учруулах магадлал багатай. Харин Оюу толгой-Гашуун сухайт чиглэлийн 100 гаруй км автозамын болзошгүй нөлөөлөл нь эдгээр амьтдыг автозамаас дайжихад хүргэж, автозамын нөлөөллийн бүсэд нүүдэллэн амьдардаг хулан, зээрийн нүүдлийн шилжилт хөдөлгөөн буурахад хүргэж болзошгүй. Онцгой тохиолдолд уг автозам нь амьтдын шилжилт хөдөлгөөнд бүрэн хаалт болж болзошгүй. Зэрлэг амьтдын автозамаас дайжих, автозамаар зааглагдах байдлыг бууруулах нь Рио Тинтогийн сайн дурын Биологийн олон янз байдлын стратеги, мөн Олон улсын санхүүгийн корпорацийн (ОУСК) Гүйцэтгэлийн стандарт 6 (PS6), Европын сэргээн босголт хөгжлийн банкны (ЕСБХБ) Гүйцэтгэлийн шаардлага 6 (PR6) зэрэг зээлдүүлэгч нартай байгуулсан гэрээний хүрээнд “Оюу толгой” компанийн хүлээсэн үүрэг хариуцлага юм.

Хяналт шинжилгээний тайлан зэрэг төслийн баримт бичгийг судалж, ярилцлага хийж (ОТ-н ажилтан, техникийн зөвлөх, зээлдүүлэгч нартай), төслийн талбайд очиж танилцсаны үндсэн дээр тус Баг дараах дүгнэлтийг гаргаж байна:

1. Зэрлэг амьтдын автозамаас дайжих, автозамаар зааглагдах байдалд хийсэн хяналт шинжилгээгээр хараахан дүгнэлтэд хүрч чадаагүй байгаа бөгөөд цаашдаа ч боломжит арга хэрэгслийг ашиглан дүгнэлтэд хүрч чадахгүй байх эрсдэлтэй байна. Сүүлийн хэдэн жилийн судалгаанаас харахад судалгаанд хамрагдсан амьтад өргөн уудам нутаг дэвсгэрт нүүдэллэн явдаг тул автозамын ойролцоо буй бодгалиудыг нэгбүрчлэн хамруулж хангалтай хэмжээний түүвэр үүсгэн судлахад хүндрэлтэй байна. Цаашлаад автозамын нөлөөлөлд орсон бага хэмжээний газар нутагт хийсэн судалгаагаар өргөн уудам нутаг дэвсгэрт нүүдэллэн явдаг эдгээр төрөл зүйлсэд үзүүлэх нөлөөг харьцуулан гаргахад төвөгтэй юм. Эдгээр төрөл зүйлсийн амьтдын автозамаас дайжих, автозамаар зааглагдах байдлыг нь тодорхойлоход тун ярвигтай байдаг.
2. ОТ нь хурдны хязгаар тогтоох, жолооч нарын мэдлэг ойлголтыг дээшлүүлэх байдлаар автозамын нөлөөллийг бууруулах арга хэмжээ авч

*ОТ-н автозамын нөлөөллийг бууруулах стратегийн талаарх хөндлөнгийн мэргэжлийн шинжээчдийн тайлан*

байна. ОТ сөрөг нөлөөг бууруулах өөр бусад хувилбаруудыг үнэлж үзсэн бөгөөд цөөн хэдэн хувилбар л хэрэгжих боломжтой буюу үр дүнтэй байх магадлалтай ба өөр боломжит хувилбар төдийлэн байхгүй тул хяналт шинжилгээ хийснээр менежментэд мэдэгдэхүйц өөрчлөлт гарах төлөвгүй байна.

3. ОТ-н Эерэг Ахиу Нөлөөлүзүүлэх урьдчилсан таамгаар *дүйцүүлэн хамгааллын төлөвлөгөө нь автозамын цаашдын боломжит нөлөөллийг хэдийнэ нөхсөн төдийгүй үлэмж хэмжээгээр давуулан биелүүлнэ* гэж тооцоолж байна. Үүнээс үүдэн, хэдийнэ тодорхой хэмжээгээр өртөх нь тодорхой болсон зэрлэг амьтдын автозамаас дайжих, автозамаар зааглагдах байдлыг нарийвчлан үнэлэхэд хөрөнгө оруулах уу, эсвэл дүйцүүлэн хамгааллын арга хэмжээг сайн хэрэгжүүлэхэд хөрөнгө оруулах уу гэсэн асуулт урган гарч ирж байна.

Эдгээр дүгнэлтүүдэд тулгуурлаж тус Баг дараах зөвлөмжийг өгч байна:

1. Автозамын нөлөөллийг бууруулахаар хэрэгжүүлэх нэмэлт эсвэл боломжит өөр хувилбар маш ховор, мөн ийм нэмэлт/боломжит өөр хувилбарыг хэрэгжүүлэх замаар хөрвөх менежментийн хэрэгжүүлэх боломж хязгаарлагдмал болохыг хүлээн зөвшөөрөх.

*Боломжит* нэмэлт сайжруулалтуудад дараах ажлууд орно. Үүнд:

- Жолооч нарт зэрлэг амьтдын талаарх мэдлэг/мэдээллийг ойр ойрхон өгөх;
- Амьтад автомашинд мөргүүлэх эрсдэл өндөртэй автозамын хэсгүүдэд хурдны хязгаарыг шинэчлэн тогтоох;
- Жолооч нарын зэрлэг амьтдын талаарх мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх үүднээс хяналт шинжилгээний ажилд жолооч нарыг оролцуулах;
- Гэрээт гүйцэтгэгчдийг автозамын хяналт (GPS-ээр автомашины хурдыг хянах г.м.) -д бүрэн хамруулах;
- Амьтдыг автомашинд мөргүүлэхээс сэргийлэх байдлыг сайжруулж чадна гэж *үзвэл* автомат тоормозтой эсвэл автомат жолоодлоготой ачааны тэрэг явуулах.

2. Амьтад автозамаас дайжихтай холбоотой автозамын шууд бус нөлөөллийг хянах боломжит *арга хэрэгсэл* мөн *үр дүн* нь ямар байж болохыг үнэлэх. Хяналт шинжилгээний менежментийг чиглүүлэх зорилгоор ашиглана. Гэсэн хэдий ч, менежментийн бусад боломжууд хязгаарлагдмал бөгөөд амьтад автомашинд мөргүүлж үхэх зэрэг шууд нөлөөллүүдийг хянах замаар голчлон удирдана. Үүнээс гадна, ОТ нь Оюу толгой-Гашуун сухайтын автозамын улмаас амьтдын амьдрах орчинд учирсан нийт хохирлыг хэд дахин нөхөхөөр хэмжээнд биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалахаар зорьж байгааг дурдах нь зүйтэй. Иймийн тул, менежментийн арга хэмжээнд нөлөө үзүүлэх чадваргүй тул шууд бус нөлөөллийг хянах нь практикийн хувьд хязгаарлагдмал байна. Түүнчлэн,

харьцангуй бага талбай дахь амьдрах орчны өөрчлөлт нь маш өргөн уудам нутаг дэвсгэрт нүүдэллэн амьдардаг амьтдад ямар нөлөө үзүүлэхийг судлан тогтооход хүндрэлтэй учир шууд бус нөлөөллийг хяналтын үр дүн хязгаарлагдмал байх болно.

Тиймээс, боломжит хоёр арга зам байна. Нэгдүгээрт, ОТ автозамын шууд бус нөлөөллийн талаарх ойлголтыг сайжруулахын тулд хяналт шинжилгээ, судалгаагаа нэмэгдүүлэх явдал юм. Ингэснээр автозам амьтдын зан төрөхд хэрхэн нөлөөлж буй талаар нарийвчилсан ойлголттой болох хэдий ч, хяналт шинжилгээ, судалгааны үр дүн ямар гарахаас үл хамааран авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээ нь биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ байх болно. Нөгөө арга зам нь, хяналт шинжилгээнд гол анхаарлаа хандуулах бус, биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ хэр үр нөлөөтэй байгааг үнэлэхэд гол анхаарлаа хандуулах явдал юм.

3. Хэрэв шууд бус нөлөөллийн хяналт шинжилгээнд зарцуулах хүчин чармайлтыг биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгааллын хяналт шинжилгээнд зарцуулж мөн мэргэжилтнүүдтэй хамтарснаар хяналт шинжилгээг багцаар нь дахин шалгах боломжтой гэж бид үзэж байна. Ийм боломж байгаа нь хэд хэдэн зүйл дээр ажиглагдсан бөгөөд ялангуяа амьтдын тоо толгойн хяналт шинжилгээ хийх явцад тодорхой харагдаж байсан. Мөн хар сүүлт зээр нөлөөлөлд илүү өртөж буй байдал мөнэнэхүү зүйлийн талаар хангалттай мэдээлэл байхгүй тул хар сүүлт зээрийн судалгаанд илүү анхаарал хандуулах хэрэгтэй гэдэг нь ажиглагдсан. Бидний ажлын зорилгод тусгагдаагүй тул бидний зүгээс хяналт шинжилгээний мэргэжилтнүүдэд тусгайлсан зөвлөмж өгөхөөс түдгэлзэж байна. *Гэвч хулан болон хар сүүлт зээрийг дүйцүүлэн хамгаалах ажил дээр нарийвчилсан хяналт шинжилгээг үргэлжлүүлэн хийх шаардлагатай* байгааг онцлон тэмдэглэхийг хүсэж байна.

Тус багийн үзэж буйгаар Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт буй хулан, зээрийн сүрэгт шугаман дэд бүтэцмөн малын бэлчээр, хулгайн ан зэрэг хүний үйл ажиллагаанаас шалтгаалсан урт хугацааны хуримтлагдсан нөлөөлөл илүү анхаарал татаж байна. ОТ-н оруулах хамгийн том хувь нэмэр мөн хулан болон хар сүүлт зээрийн төрөл зүйлд эерэг ахиу нөлөө үзүүлэх үзүүлэх хамгийн сайн арга зам нь Оюу толгой-Гашуун сухайтын автозам биш харин байгаль орчинд хамгийн их ачаалал, дарамт учруулж буй бусад эх үүсвэрүүдэд анхаарлаа хандуулах замаар Өмнөговь аймгийн хэмжээнд урт хугацаанд хуримтлагдах нөлөөллийг бууруулах зорилгоор биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэх, мөн уг хөтөлбөрөөс хуримтлуулах шинжлэх ухааны мэдлэг дээрээ тулгуурлаад дүйцүүлэн хамгааллын хүчин чармайлтуудыг дэмжиж ажиллах явдал юм гэж манай баг үзэж байна. Тэр дундаа ОТ-н автозамын нөлөөллийг бууруулах бусад арга хэлбэр хязгаарлагдмал болохыг тооцож үзвэл энэ нь илүү ач холбогдолтой юм.